



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/217

Улаанбаатар хот

Улсын комисс томилон
ажиллуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.13, Эрчим хүчний сайдын 2019 оны 125 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам”-ын 3.2, “Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 1/687 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт үйлдвэрийн 6 кВ-ын кабель шугам, 6/0.4 кВ-ын 630 кВА дэд станц”-ын барилга угсралтын ажил дууссантай холбогдуулан уг барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсугай.

Комиссын дарга:

Д.Батзориг

Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахилгааны хэлтсийн дарга

Гишүүд:

М.Мөнхболд

Багахангай дүүргийн Онцгой байдлын газрын Гал түймрийн Улсын хяналтын байцаагч, ахмад

Н.Өлзийцэцэг

Багахангай дүүргийн Архивын тасгийн архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагч

Д.Зоригтбаатар

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Налайх түгээх төвийн засварын инженер

Д.Саруулмягмар

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Налайх түгээх төвийн борлуулалтын инженер

Н.Мөнх-Оргил

“Ян сарьдаг оргил” ХХК-ийн төслийн удирдагч бөгөөд захиалагч (зөвшилцсөнөөр)

Г.Нурдаулет

“Прожект Дизайн Консалтинг” ХХК-ийн захирал бөгөөд зургийн зохиогч (зөвшилцсөнөөр)

Г.Баярхүү

“Нар энерги селикон метал” ХХК-ийн инженер бөгөөд барилга угсралтын ажлын гүйцэтгэгч (зөвшилцсөнөөр)

17060000015

2.

Нарийн бичгийн дарга:
Б.Энхнасан

“Эрчим хүчний үндэсний төв” ТӨХХК-ийн Захиалагч,
техник хяналтын хэлтсийн хяналтын инженер.

2. Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллахыг Улсын комисс (Д.Батзориг)-т даалгасугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН